



**МОНГОЛ УЛС:  
МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТЫН  
ХЭРЭГЖИЛТ,  
2015 ОНООС ХОЙШИХ ХӨГЖЛИЙН  
ЗОРИЛТУУД**





**МОНГОЛ УЛС: МЯНГАНЫ ХӨГЖЛИЙН  
ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ,  
2015 ОНООС ХОЙШИХ ХӨГЖЛИЙН  
ЗОРИЛТУУД**

2014 оны 6 дугаар сар

## АГУУЛГА

1. Мянганы тунхаглал болон МХЗ
2. МХЗ-ын Зорилгууд
3. Монгол улсын МХЗ-ын 9 дэх зорилго
4. Монгол улсын МХЗ-ыг баталсан төр, засгийн шийдвэр
5. МХЗ-ыг үндэсний төлөвлөлттэй уялдуулах нь
6. МХЗ-д хүрэхэд төр, засгийн байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлага
7. МХЗ-ын тайлагнал, үнэлгээ
8. Монгол улсын МХЗ-ын хэрэгжилтийн өнөөгийн байдал
9. 2015 оноос хойших хугацааны хөгжлийн зорилтууд

## 1. Мянганы Тунхаглал ба МХЗ

2000 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн гишүүн 189 орны төр, засгийн тэргүүн нар Мянганы Тунхаглалыг баталсан.

Мянганы Хөгжлийн Зорилтууд нь Мянганы тунхаглал дээр үндэслэгдсэн бөгөөд дэлхий дахинд хөгжлийн тулгамдсан асуудлуудаар 2015 он гэхэд хүрэхээр дэвшүүлсэн багц найман зорилгоос бүрддэг.

## 2. МХЗ-ын Зорилгууд

МХЗ-ийн зорилгууд:

ЗОРИЛГО 1: Ядуурал, өлсгөлөнг бууруулах

ЗОРИЛГО 2: Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших

ЗОРИЛГО 3: Жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

ЗОРИЛГО 4: Хүүхдийн эндэгдлийг бууруулах

ЗОРИЛГО 5: Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах

ЗОРИЛГО 6: БЗХӨ, ХДХВ, ДОХ, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах

ЗОРИЛГО 7: Байгаль орчны тогтвортой байдлыг хангах

ЗОРИЛГО 8: Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх

Эдгээр зорилго тус бүр нь өөр өөр зорилт, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлттэй. Зорилго бүрийн дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралтаас үзнэ үү.

## 3. Монгол улсын МХЗ-ын 9 дэх зорилго

Монгол улс бол МХЗ-доо 9 дэх зорилгыг нэмж баталсан цөөн хэдэн орны нэг юм.

Сайн засаглалыг хөгжүүлж, нийгэм эдийн засгийн хөгжил, байгаль орчны тогтвортой байдлыг хангахын ач холбогдлыг үнэлж Монгол улсын УИХ-аас “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх” 9 дэх зорилгыг 2008 онд баталсан билээ.

## 4. МХЗ-ыг баталсан төр, засгийн шийдвэр

Монгол улсын МХЗ-той холбоотой гарсан төр, засгийн тогтоол шийдвэрийн он дарааллын жагсаалт:

Огноо	Тогтоол/Шийдвэр	Үйл ажиллагаа
2005 оны 4 дүгээр сарын 21	Улсын Их Хурлын 25 дугаар тогтоол	Монгол улсын МХЗ-д "Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх" 9 дэх зорилгыг нэмж оруулан баталсан.
2006 оны 1 дүгээр сарын 6	УИХ-ын Байнгын хорооны тогтоол	МХЗ-ын хэрэгжилтийг хангах, статистик мэдээллийг тооцох аргачлалыг сайжруулах, зохицуулах үүрэгтэй Удирдах Зөвлөлийг байгуулсан.
2006 оны 2 дугаар сарын 23	Монгол улсын Ерөнхийлөгчийн 5 тоот зарлиг	Үндэсний хөгжлийн цогц бодлого боловсруулах ажлын хэсгийг байгуулсан.
2006 оны 3 дугаар сарын 14	Ерөнхий сайдын 28 тоот захирамж	Хэрэгцээ, шаардлагыг судлах ажлын хэсэг байгуулсан.
2006 оны 3 дугаар сарын 22	Монгол улсын Засгийн газрын 53 дугаар тогтоол	МХЗ-д хүрэхийн тулд авах шаардлагатай арга хэмжээг баталсан.
2008 оны 1 дүгээр сарын 31	Улсын Их Хурлын 13 дугаар тогтоол	УИХ-ын 25 дугаар тогтоолд тодотгол хийж, МХЗ-ыг 24 зорилт, 67 шалгуур үзүүлэлттэй 9 зорилгын хүрээнд баталсан.
2008 оны 2 дугаар сарын 12	Улсын Их Хурлын тогтоол	МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг баталсан.
2009 оны 4 дүгээр сарын 15	Монгол улсын Засгийн газрын 113 дугаар тогтоол	25 дугаар тогтоолын хэрэгжилтэд тодотгол хийсэн.

## 5. МХЗ-ыг үндэсний төлөвлөлттэй уялдуулах нь

Улсын Их Хурлын 2008 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн тогтоолоор МХЗ-ыг Засгийн газрын үндэсний төлөвлөлтийн үйл явцад оруулж, Засгийн газарт дараах зүйлийг даалгасан. Үүнд:

- Засгийн газрын мөрийн хөтөлбөр, улсын төсөв болон жил бүрийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн гол удирдамжид тусгагдсан МХЗ-д суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого (ҮХЦБ)-ын стратеги зорилтыг хэрэгжүүлэх, зохион байгуулахтай холбоотой арга хэмжээ авах;
- МХЗ-д суурилсан (ҮХЦБ)-ын дагуу Үндэсний хөтөлбөрүүдийг шинэчлэх, шинээр дахин нарийвчлан боловсруулах болон хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- МХЗ-д суурилсан (ҮХЦБ)-ын стратеги зорилтыг хэрэгжүүлэх зорилготой төсөл хөтөлбөрүүд, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийг нарийвчлан боловсруулахтай холбоотойгоор цаашид авах арга хэмжээний талаар төр, засгийн холбогдох байгууллагуудад зөвлөмж гаргах, УИХ-аар батлуулахаар өргөн барих, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгуулах болон хэрэгжилтийг зохион байгуулах;

## 6. МХЗ-д хүрэхэд төр, засгийн байгууллагуудын хүлээх үүрэг, хариуцлага

МХЗ-ын зорилгууд		Хариуцах яам/агентлаг
Зорилго 1	Ядуурал, өлсгөлөнг бууруулах	<ul style="list-style-type: none"> <li>Эдийн Засгийн Хөгжлийн Яам</li> <li>Сангийн Яам</li> <li>Хүн Амын Хөгжил, Нийгмийн Хамгааллын Яам</li> <li>Хөдөлмөрийн Яам</li> </ul>
Зорилго 2	Бүх нийтээр анхан шатны боловсрол эзэмших	<ul style="list-style-type: none"> <li>Боловсрол, Шинжлэх Ухааны Яам</li> </ul>
Зорилго 3	Жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Жендэрийн Үндэсний Хороо</li> <li>Хөдөлмөрийн Яам</li> </ul>
Зорилго 4	Хүүхдийн эндэгдлийг бууруулах	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл Мэндийн Яам</li> </ul>
Зорилго 5	Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл Мэндийн Яам</li> </ul>
Зорилго 6	БЗХӨ, ХДХВ, ДОХ, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах	<ul style="list-style-type: none"> <li>Эрүүл Мэндийн Яам</li> </ul>
Зорилго 7	Байгаль орчны тогтвортой байдлыг хангах	<ul style="list-style-type: none"> <li>Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам</li> </ul>
Зорилго 8	Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Гадаад Харилцааны Яам</li> <li>Эдийн Засгийн Хөгжлийн Яам</li> </ul>
Зорилго 9	Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>Хүний Эрхийн Үндэсний Комисс</li> <li>Хууль Зүйн Яам</li> <li>Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар</li> <li>Авлигатай Тэмцэх Газар</li> </ul>

Үндэсний Статистикийн Хороо нь МХЗ-ын тодорхой зорилгын шалгуур үзүүлэлтийг тооцоход шаардлагатай тоон мэдээллийг цуглуулж өгөх үүрэгтэй.

## 7. МХЗ-ын тайлагнал, үнэлгээ

МХЗ-ын хэрэгжилтийн явцад үнэлгээ хийх үүргийг Эдийн засгийн хөгжлийн яам хариуцаж ажилладаг.

УИХ-ын 2009 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 113 тоот тогтоолоор Засгийн газар 2 жил тутам МХЗ-ын хэрэгжилтийн явцын тайланг гаргаж байхаар тогтсон.

Монгол улс 2004 оноос хойш МХЗ-ын хэрэгжилтийн явцын 5 удаагийн тайланг гаргасан. Тав дахь удаагийн тайланг НҮБ-ын МХЗ-ын сэдэвт тусгай чуулганд танилцуулахаар 2013 оны 9 дүгээр сард бэлтгэн гаргасан.

## 8. Монгол улсын МХЗ-ын өнөөгийн байдал

Монгол улс МХЗ-ын олон зорилгодоо хүрч ихээхэн амжилттай байгаа хэдий ч зарим нэг нь байх ёстой түвшиндээ, зарим нэг нь удаашралтай, зарим нэг нь үнэлэх тоон мэдээллээ хэрхэн бүрдүүлэх асуудлаа шийдвэрлээгүй гэх мэт холимог дүр зураг харагдаж байна. Зарим үзүүлэлтийн хувьд 2015 он гэхэд тавьсан зорилтдоо хүрэхийн тулд нэмэлт хүчин чармайлт шаардагдахаар байна. МХЗ-ын хэрэгжилтийн байдлыг Хүснэгт 1-т үзүүлсэн.

Хүснэгт 1. МХЗ-ЫН ХЭРЭГЖИЛТ: МОНГОЛ УЛС ХЭРХЭН ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙНА?

Мянганы хөгжлийн зорилт	Дүгнэх боломжгүй	Биелэх боломжгүй	Нэмэлт арга хэмжээ авснаар хэрэгжих боломжтой	Биелэх боломжтой	Бүрэн биелсэн
<b>МХЗ 1: ЯДУУРАЛ, ӨЛСГӨЛӨНГ БҮҮРУУЛАХ</b>					
Зорилт 1: Амьжиргааны даяад түвшингээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах					
Зорилт 2: Хол, тэжээлийн дутагдалтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 6 дахин бууруулах					
Зорилт 3: Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж буй залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах					
Зорилт 4: Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах	x				
<b>МХЗ 2: БҮХ НИЙТЭЭРЭЭ АНХАН ШАНН БАТОВСРОЛ ЭЗЭМШИХ</b>					
Зорилт 5: 2015 он гэхэд бүх хүүхэд бага боловсрол олгох					
<b>МХЗ 3: ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ДЭМЖИН ХӨГЖҮҮЛЖ, ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЭМЭГТЭЙНҮҮДИЙН ОРЛОЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ</b>					
Зорилт 6: 2009 он гэхэд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралтагчдын хүснэгийн зохихцаг хангах					
Зорилт 7: Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жөндөрийн тэгш байдлыг хангах					
Зорилт 8: Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйнүүдийн оролцоог нэмэгдүүлэх					
<b>МХЗ 4: ХҮҮДИЙН ЭНДЭГДЛИЙГ БҮҮРУУЛАХ</b>					
Зорилт 9: Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах					
<b>МХЗ 5: ЭХҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ САЙЖРУУЛАХ</b>					
Зорилт 10: Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах					
<b>МХЗ 6: ӨЗЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧИН, ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУС (ИДХВ), ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ (ДОХ), СУРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ, БУСАД ӨВННИЙГ БҮҮРУУЛАХ</b>					
Зорилт 11: 2015 он гэхэд ИДХВ, ДОХ өвчний халдварыг хязгарлах, урьдчилан сэргийлэх					
Зорилт 12: 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах					
Зорилт 13: Хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах	x				
<b>МХЗ 7: БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ</b>					
Зорилт 14: Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот, суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх					
Зорилт 15: Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах					
Зорилт 16: 2015 он гэхэд баталгаат үндэс усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах					
Зорилт 17: 2015 он гэхэд хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулах					
<b>МХЗ 8: ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨ ДЭЛМИЙН НИЙТИЙН ТҮНШЛЭЛИЙГ ХӨГЖҮҮЛЭХ</b>					
Зорилт 18: Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар Мянганы хөгжлийн зарилтуудыг хангах тасай нөхцөл бүрдүүлэх					
Зорилт 19: Дотоод гарцуйг Монгол Улсын онцгой хэрэгцээ, шаардлагыг харгалзан илүү тасламжтай нөхцөлөөр дотоод гарцуй болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх					
Зорилт 20: Үрт хуацанд гадаад дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад харьгалж байгаа арга хэрэгслийг судлах, Монгол Улсын төсөв, эдийн засагт хүрддэй уруулахагүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх					
<b>МХЗ 9: ХҮНИЙ ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ, АРДЧИЛСАН ЗАСАЛЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ</b>					
Зорилт 21: Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, "Мэдээлэлжсэн нийгэм" байгуулах					
Зорилт 22: Хүний эрхийн түгээмэл тунхагалыг хүндэтгэн сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөт ханган, олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох					
Зорилт 23: Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх	xx				
Зорилт 24: Авлигын үл тэмчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх	xx				
xx	xx				

Тайлбар: x – Мэдээлэл дутмаг; xx – Зорилтот түвшинг тодорхойлоогүй. Ашигласан эх үүсвэр: Монгол улсын Засгийн газраас гаргасан “Монгол улсын МХЗ-уудын хэрэгжилт” Үндэсний 5 дахь илтгэл, Улаанбаатар хот. 2013 он


## 9. 2015 оноос хойших хөгжлийн зорилтууд

2015 онд МХЗ-д хүрэх хугацаа ойртох тусам МХЗ-ыг цаашид хэрхэн амжилттай хэрэгжүүлэх талаар улс орнууд хэлэлцүүлэг өрнүүлж эхэлсэн бөгөөд сүүлийн нэг жилийн хугацаанд НҮБ-аас үндэсний хэмжээний 88 хэлэлцүүлэг, сэдэвчилсэн 11 хэлэлцүүлгийг зохион байгуулж, 1 сая гаруй хүнийг хамруулсан дэлхийн хэмжээний судалгаа явуулсан байна.

Энэхүү судалгаанд Монгол улс ч мөн оролцсон бөгөөд судалгааны дүнг Зураг 1-д үзүүлсэн. Монгол улс дахь НҮБ-ын төлөөлөгчийн газар төр, засгийн болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран төрөл бүрийн хэлэлцүүлэг, зөвлөлдөх уулзалтуудыг зохион байгуулж, үзэл бодлоо тэр бүр илэрхийлэх боломж тааруу хүн амын бүлгийнхний оролцоог хангах тал дээр ихээхэн анхаарал хандуулсан юм. Тэдгээр хэлэлцүүлэг, судалгааны дүнд **“Сая сая санал: Бидний хүсэж буй дэлхий”** хэмээх илтгэл гарсан юм. Илтгэлийг [www.worldwewant2015.org/millionvoices](http://www.worldwewant2015.org/millionvoices) хаягаар татаж авах боломжтой.

Зураг 1. МИНИЙ Дэлхий судалгаа: Монгол улсын судалгааны нэгтгэл

Монгол улсын судалгааны нэгтгэл  
<http://www.worldwewant2015.org/>



## 2015 оноос хойших хөгжлийн зорилтуудыг тодорхойлох нь:

### Монгол улсад өрнөсөн хэлэлцүүлгүүд

2015 оноос хойших хөгжлийн зорилтыг тодорхойлох “Бидний хүсэж буй ирээдүй” сэдэвт үндэсний хэлэлцүүлгийн хүрээнд НҮБ-ын Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас 2012 оны 12 дугаар сараас 2013 оны 5 дугаар сар хүртэл хэд хэдэн цуврал хэлэлцүүлгийг төр засаг, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулсан бөгөөд эдгээр хэлэлцүүлэгт нийтдээ 2000 гаруй төлөөлөгч нийгмийн янз бүрийн бүлгийг төлөөлөн оролцож саналаа солилцсон.

Хэлэлцүүлгийг хоорондоо харилцан хамааралтай, тус тусад нь салангид шийдэх боломжгүй Эдийн засаг, Нийгэм, Байгаль орчин гэсэн гурван үндсэн чиглэлийн хүрээнд явуулсан бөгөөд эдгээр хэлэлцүүлгээс дараах саналууд гарсан. Үүнд:

### Засаглалыг хөгжүүлэх

1. Монгол улс нь ардчиллыг хөгжүүлэх, иргэний нийгмийг бэхжүүлэх тал дээр ихээхэн анхаарч байгаа бөгөөд МХЗ-ын 9 дэх (хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх) зорилгыг нэмж баталсан. Хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх болон нийгэм, эдийн засаг, соёлын эрхийг өөртөө багтаасан Мянганы тунхаглалын зарчмуудыг 2015 оноос хойших хөгжлийн зорилтод цогцоор нь тусгаж авч үзэхийг дэлхийн улс орнуудад хандан уриалах;
2. Эмзэг, цөөнх бүлгийн эрх ашгийг хамгаалах, тэдэнд хэрэгцээт үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргах түвшинд оролцох оролцоог нь нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарал хандуулах;
3. Монгол улсад мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи асар хурдацтайгаар нэвтэрч, олон нийтийн мэдээллийн сүлжээний хэрэгслийг өргөнөөр ашиглаж байгаа нь ирээдүйн өөрчлөлтийн маш чухал хэрэгсэл нь болж байна. Тэдгээр нь ард иргэд, эмзэг бүлгийнхэнд мэдээлэл олж авах, шийдвэр гаргах үйл явцад дуу хоолойгоо хүргэх арга хэрэгсэл болон ашиглагдаж болох юм.

### Эдийн засаг

4. Уул уурхайн үсрэнгүй хөгжлийн үр дүнд Монгол улсын эдийн засаг ихээхэн хурдацтай хөгжиж, бага орлоготой улс орноос дундаж орлоготой улс орнуудын түвшинд очсон. Монгол шиг олборлох үйлдвэрээс ихээхэн хамааралтай улс орнууд өргөн хэрэглээний үнэ ханшийн хэлбэлзэлд өртөхдөө хялбар бөгөөд ирээдүйн хөгжилд эдийн засгийн өсөлт нөлөөтэй ч эдийн засгийн төрөлжүүлэлт, орон нутгийн хувийн хэвшлийн салбарын хөгжил зайлшгүй чухал зүйл юм.
5. Эдийн засгийн тэгш бус байдал даамжрах нь өнөөгийн ололтуудаа няцаах аюултай. Шинэ хөтөлбөрөөр тэгш бус байдлыг багасган, хүртээмжтэй, тэгш өсөлтийг хангахад ихээхэн ач холбогдол өгөх нь зүйтэй. Мөн түүнчлэн ядуу, цөөнх бүлгийнхнийг эмзэг байдлаас нь гаргах уян хатан, нийгмийн хамгааллын бодлогод анхаарлаа хандуулах шаардлагатай байна.
6. Далайд гарцгүй орны хувьд Монгол улс нь бүс нутгийн худалдааны сүлжээ болон “өмнөдөөс өмнөд”-ийг идэвхтэй дэмжин гурван талт харилцааг баримтлах нь хөгжих боломжийг бүрдүүлэхэд түлхэц болох юм.

## Соёл, нийгэм

7. Уламжлалт мал аж ахуй болон нүүдлийн соёлыг өөртөө агуулсан монголын соёл, уламжлал, түүх нь байгалиа унаган төрхөөр нь хамгаалж үлдэх, ирээдүйн боломжийг нээж өгөх түлхүүр байж болох юм.
8. Залуус бол эх орны хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл нь юм. Залуусын ажилгүйдэл өндөр байгаа нь боловсролын чанар муугаас хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэнд нийцэхгүй байгаатай холбоотой. Мөн хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл дутмаг, зээл авах боломж тааруу, чанар муутай эрүүл мэндийн үйлчилгээ болон цөөнх ястнууддаа хандуулах анхаарал сул байгаа зэрэг нь залуучуудыг өөрсдийнхөө бүрэн хүчин чадлыг нээж, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах боломжийг нь хязгаарлаж байна.
9. Хэдийгээр залуус улс орны ирээдүйд их үүрэгтэй ч насжилт бол бас нэгэн асуудал юм. Тэгш халамжийг хүртээх үүднээс ахимаг настнуудыг ажлын байраар хангах, нийгмийн даатгалд хамруулах нь чухал байна.
10. Монголын ирээдүй болсон хүүхэд багачуудын боловсрол, эрүүл мэнд, усны хангамж, эрүүл ахуй, хоол тэжээлийн байдлыг сайжруулах, түүнчлэн ядуурал, байгаль цаг уурын гамшигт өртөмтгий байдал, хүүхэд хамгааллын асуудалд илүү ихээр анхаарал хандуулах хэрэгтэйг бидэнд сануулж байна.
11. Эмэгтэйчүүдийн ур чадварыг сайжруулах, тэднийг жижиг дунд бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажлын байран дээрх ялгаварлан гадуурхах явдлыг бууруулах нь жендэрийн тэгш байдлыг хангах, эмэгтэйчүүдийн эдийн засгийн эрх мэдлийг нь бэхжүүлэхэд чухал үүрэгтэй.
12. Бодлого боловсруулахад ямагт орхигдож байдаг эмзэг бүлгийнхэн ба бусад хэсгийнхнийг ч мөн цаашид анхааралдаа авсан хэвээр байх ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ялгаварлан гадуурхах явдлыг эцэс болгоход онцгой анхаарал хандуулах хэрэгтэйг цохон тэмдэглэсэн.

## Байгаль орчин

13. Цаг уурын өөрчлөлт, байгалийн гамшиг, хүлэмжийн хийн ялгарал, усны бохирдол, хөрсний элэгдэл, цөлжилт, биологийн төрөл зүйлийн тэнцвэрийн алдагдал гэх мэт байгаль орчны асуудлууд нь Монгол улсад хурцаар тавигдаж байгаа бөгөөд ялангуяа малчид, тариаланчдын амьжиргаа энэхүү байгалийн бэрхшээлд ихээр өртөж байна. 2015 оноос хойших хөгжлийн зорилтуудын хүрээнд тогтвортой хөгжлийн асуудалд хариуцлагатай уул уурхай, ногоон эдийн засаг болон сэргээгдэх эрчим хүчийг ашиглах талаар түлхүү оруулах нь зүйтэй хэмээн үзсэн байна.
14. Шинээр гаргасан Хүний тогтвортой хөгжлийн индексэд нэг хүнд ноогдох хүлэмжийн хийн ялгаруулалтын хэмжээгээр орлого болон тэгш бус байдлыг хэмжиж болно гэсэн байна. Ингэснээр улс орнуудын тогтвортой хөгжих бололцоог дэмжиж байгаа юм.

## Бүс нутгийн болон орон нутгийн хөгжил

15. Орон нутгийн төлөөллүүд хэтийн зорилгоо орон нутгийн засаг захиргааны чадавхийг дээшлүүлэх, бүс нутгийн болон орон нутгийн хөгжлийн санхүүжилтийг тэгш хуваарилах, хот байгуулалт, төлөвлөлтийг сайжруулах ба дэд бүтцийг сайжруулан орон нутгийн бизнесийг дэмжих гэсэн үндсэн хэсгүүдэд хуваан дэвшүүлсэн байна.

**2015 оноос хойших хөгжлийн асуудлаарх хоёр дахь үе шатны хэлэлцүүлэг 2014 онд олон улсад өрнөж, хэрэгжүүлэх арга замын талаар анхаарал хандуулж байна.** Энэ учраас Монгол улс дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Суурин төлөөлөгчийн газар, НҮБ-ын Үйлдвэр Хөгжлийн Байгууллагын дэмжлэгтэйгээр энэ удаагийн хэлэлцүүлгийг хувийн хэвшлийг оролцуулан зохион байгуулахаар шийдвэрлэсэн юм. Учир нь хувийн хэвшил бол Монгол улсын эдийн засаг, түүний олон талт хөгжлийн гол хөдөлгөгч хүчин зүйл мөн гэдэг нь тодорхой. Хэлэлцүүлэг, цуврал уулзалтуудыг 2014 оны 6 дугаар сарын дундаас 8 дугаар сарын эцэс хүртэлх хугацаанд хийхээр төлөвлөж байгаа бөгөөд уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнг олон нийтэд зориулсан тусгай вебхуудсанд байршуулах болно.

Хувийн хэвшлийнхэнтэй хийх хэлэлцүүлгүүдийг дараах сэдвээр явуулна:

- *Тогтвортой хөгжилд Хувийн хэвшлийн оруулах хэвь нэмрийг нэмэгдүүлэх нь*
- *Ил тод байдал, хариуцлагатай байдлыг сайжруулах замаар итгэлцлийг бий болгох*

Хэлэлцүүлгүүд нь байгаль орчны тогтвортой хөгжлөөс гадна нийгмийн хариуцлага, нийтлэг шинжтэй (Жишээ нь, жендэр, өсвөр үе залуучуудын асуудал, хүний эрх ба тэгш бус байдал гэх мэт) асуудлуудад ч мөн анхаарал хандуулах болно. Сэдэвчилсэн уулзалтын талаар нэмэлт мэдээллийг хэлэлцүүлэг хамтран зохион байгуулагчийн зүгээс бэлтгэн түгээнэ.

МХЗ-уудын хэрэгжилтэнд төр, засаг давамгайл үүрэгтэй оролцсон ба 2015 оноос хойших хөгжлийн зорилтын талаар хувийн хэвшлийнхэн бүрэн гүйцэд, цогц ойлголтгүй байсаар байна. Тийм ч учраас эдгээр хэлэлцүүлэг нь Тогтвортой Хөгжлийн Зорилтууд (ТХЗ) болон НҮБ-ын хөгжлийн асуудлаар ойлголт өгөх, тодорхойлсон ТХЗ-уудын хэрэгжилтэнд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой.

2015 оноос хойших хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн гүйцэтгэх үүрэг ролийг тодорхойлоход тал бүрийн оролцоог жигд байлгах үүднээс энэхүү зөвлөлдөх уулзалтад холбогдох төрийн байгууллага, нийгмийн болон бусад олон талт секторуудын төлөөлөл хамрагдан оролцох болно.

## ХАВСРАЛТ

### МОНГОЛ УЛСЫН МХЗ-ЫН ЗОРИЛГУУДЫН ЖАГСААЛТ

#### **ЗОРИЛГО 1: Ядуурал, өлсгөлөнг бууруулах**

- Зорилт 1 Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой иргэдийн эзлэх хувь хэмжээг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 2 дахин бууруулах
- Зорилт 2 Хоол тэжээлийн дутагдалтай хүн амын тоог 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 6 дахин бууруулах
- Зорилт 3 Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг дээшлүүлж, хөдөлмөрийн зах зээлд шилжиж буй залуучуудын ажилгүйдлийн түвшинг бууруулах
- Зорилт 4 Хүн амын төвлөрөл, шилжих хөдөлгөөнтэй холбогдон гарч буй сөрөг үзэгдлийг багасгах, шилжин суурьшигчдыг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулах

#### **ЗОРИЛГО 2: Бүх нийтээрээ анхан шатны боловсрол эзэмших**

- Зорилт 5 2015 он гэхэд бүх хүүхдэд бага боловсрол олгох

#### **ЗОРИЛГО 3: Жендэрийн тэгш байдлыг дэмжин хөгжүүлж, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх**

- Зорилт 6 2009 он гэхэд бага болон дунд боловсрол эзэмшигчдийн дунд, 2015 он гэхэд бүх шатны боловсролын байгууллагад суралцагчдын хүйсийн зохистой харьцааг хангах
- Зорилт 7 Цалинтай ажил эрхэлж байгаа хүн амын жендэрийн тэгш байдлыг хангах
- Зорилт 8 Улс төр, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх

#### **ЗОРИЛГО 4: Хүүхдийн эндэгдлийг бууруулах**

- Зорилт 9 Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах

#### **ЗОРИЛГО 5: Эхчүүдийн эрүүл мэндийг сайжруулах**

- Зорилт 10 Нөхөн үржихүйн эрүүл мэндийн шаардлагатай тусламж үйлчилгээг хүн бүрт хүргэж, эхийн эндэгдлийг 1990 онтой харьцуулахад 2015 он гэхэд 4 дахин бууруулах

**ЗОРИЛГО 6: Бэлгийн замын халдварт өвчин, Хүний дархлал хомсдолын вирус, Дархлалын олдмол хомсдол, сүрьеэтэй тэмцэх, бусад өвчнийг бууруулах**

- Зорилт 11 2015 он гэхэд ХДХВ, ДОХ өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх
- Зорилт 12 2015 он гэхэд сүрьеэ өвчний тархалтыг бууруулах
- Зорилт 13 Хүүхдийн шүд цоорох өвчний тархалтыг бууруулах

**ЗОРИЛГО 7: Байгаль орчны тогтвортой байдлыг хангах**

- Зорилт 14 Тогтвортой хөгжлийн зарчмыг улсын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусган хэрэгжүүлж, хот, суурин, ялангуяа Улаанбаатар хотын агаарыг цэвэршүүлэх
- Зорилт 15 Гол, горхины усны эхийг хамгаалж, нөхөн сэргээх замаар ширгэлтийг багасгах
- Зорилт 16 2015 он гэхэд баталгаат ундны усны хангамжгүй, сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамрагдаагүй хүн амын эзлэх хувийг бууруулах
- Зорилт 17 2015 он гэхэд хүн амын орон сууцны нөхцөлийг сайжруулах

**ЗОРИЛГО 8: Хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийг хөгжүүлэх**

- Зорилт 18 Худалдааны болон санхүүгийн тогтолцоог хөгжүүлэх замаар МХЗ-ыг хангах таатай нөхцөл бүрдүүлэх
- Зорилт 19 Далайд гарцгүй Монгол улсын онцгой хэрэгцээ, шаардлагыг харгалзан илүү тааламжтай нөхцөлөөр далайд гарцтай болох, гадаадад дамжин өнгөрөх тээврийн үр ашгийг дээшлүүлэх, Монгол улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээврийг өргөжүүлэх
- Зорилт 20 Үрт хугацаанд гадаад, дотоод өрийн тогтвортой байдлыг хангах үүднээс өрийн стратегийг бий болгох, үндэсний болон олон улсад хэрэглэж байгаа арга хэрэгслийг судалж, Монгол улсын төсөв, эдийн засагт хүндрэл учруулахгүйгээр өрийг зохицуулан шийдвэрлэж байх
- Зорилт 21 Мэдээлэл холбооны шинэ технологийг хөгжүүлэх, “Мэдээлэлжсэн нийгэм” байгуулах

**ЗОРИЛГО 9: Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх**

- Зорилт 22 Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүндэтгэн сахиж, хэвлэл мэдээллийн эрх чөлөөг ханган олон нийтэд мэдээллийг чөлөөтэй олж авах боломж олгох
- Зорилт 23 Ардчиллын үндсэн зарчим, хэв маягийг амьдралд хэвшүүлэх
- Зорилт 24 Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх